

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.02.22

№ 04

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1	Бүтээн байгуулалт-Ажлын байрыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай	Л.Батжаргал	А.Амарзаяа	Тогтоол 14
2	Иргэний зөвлөлийн урамшууллыг шинэчлэн тогтоох тухай	А.Амарзаяа	О.Аюурзана Г.Соёлоо	Тогтоол 15
3	"Авилгын эсрэг" дэд хөтөлбөр батлах тухай	Д.Баттайван	П.Бат-Очир	Тогтоол 16
4	Хөрөнгө зарцуулах тухай	Л.Ватжаргал	А.Амарзаяа Г.Соёлоо	Тогтоол 17

**ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
АЖЛЫН АЛБА**



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 14

Есөнбулаг сум

Бүтээн байгуулалт-Ажлын байрыг  
нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. 2019 оныг аймгийн хэмжээнд “Бүтээн байгуулалт-Ажлын байрыг нэмэгдүүлэх жил” болгон зарласугай.

2. “Бүтээн байгуулалт-Ажлын байрыг нэмэгдүүлэх жил”-ийн ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулан 2019 оны 03 дугаар сарын 15-ны дотор багтааж ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж, хэрэгжилт, биелэлтийг хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА Л.Батжаргал Л.БАТЖАРГАЛ



0000053



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 15

Есөнбулаг сум

Иргэний зөвлөлийн урамшууллыг  
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус “Иргэний зөвлөл”-ийн гишүүдийн урамшууллыг улиралд 320.000 /гурван зуун хорин мянга/ төгрөгөөр тогтоож олгосугай.

2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг сайжруулж, Иргэний зөвлөлийн дүрмийн дагуу ажиллахыг зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

3. “Иргэний зөвлөл”-ийн гишүүдийн урамшуулал, үйл ажиллагаа явуулах төсвийг жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

4. Уг тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 76 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ



0000054



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 16

Есөнбулаг сум

“Авлигын эсрэг дэд хөтөлбөр”  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “Ж” заалт, Улсын Их хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нутгийн захиргааны байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хүнд суртал чирэгдэлээс ангид, төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэхэд чиглэсэн “Авлигын эсрэг дэд хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөр тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ



0000040

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2019. оны 02 дугаар сарын 22 -ны  
өдрийн 16. дугаар тогтоолын  
хавсралт

## АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ДЭД ХӨТӨЛБӨР

### Нэг.Ерөнхий мэдээлэл

Авлига нь улс орнуудын нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжилд саад тотгор учруулж, ардчилал, шинэчлэлийн явцыг сааруулах хүчин зүйл болдгийг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч, авлигатай тэмцэх санаачилга гарган тодорхой ажлуудыг хийж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр "Говь-Алтай аймгийн хөгжлийн форум-2017"-аас төрийн албыг хүнд сурталгүй, ил тод нээлттэй болгох зорилгыг дэвшүүлсэн.

2017 оны жилийн эцсийн статистик мэдээгээр аймгийн хэмжээнд 16494 өрхийн 57441 хүн ам байнга оршин сууж байна.

Хүний Нөөцийн Удирдлагын Мэдээллийн Системийн программд 2017 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн байгууллагад 4316 төрийн албан хаагч ажиллаж байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, захиргааны байгууллагаас шийдвэр гаргах үйл явцад иргэдийн санал хүсэлтийг авах, бодлого шийдвэрт тусгах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, авлига, хүнд суртлаас ангид байх, үйлчилгээг түргэн шуурхай болгох, төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх шаардлагаар энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

### Хоёр.Хөтөлбөрийн зарчим:

**Зарчим:**Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийтийн ашиг сонирхлыг дээдлэж, иргэний оролцоог хангах, хууль дээдлэх, ил тод, нээлттэй, ёс зүйтэй, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зарчмыг баримтална.

### Гурав. Хөтөлбөрийн зорилго:

**Зорилго:**Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, ил тод нээлттэй шударга, авлига хүнд сурталгүй төрийн үйлчилгээг хүргэн хууль дээдэлсэн засаглалыг бэхжүүлж, төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

### Хөтөлбөрийн зорилгыг хангах хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

Зорилт 1.Төрийн үйлчилгээний нээлттэй, хүнд сурталгүй байдлыг хангаж хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх.

Зорилт 2.Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах.

Зорилт 3. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх.

Зорилт 4. Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх.

### Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа үе, шат:

Дэд хөтөлбөрийг 2019-2020 он 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг дарга жил бүр батлан хэрэгжүүлнэ.

### Дөрөв.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

Зорилт 1.Төрийн үйлчилгээний нээлттэй, хүнд сурталгүй байдлыг хангаж хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.Нутгийн захиргааны бүх шатны байгууллагыг судалгаанд суурилж, үйлчилгээнд тулгуурласан иргэн төвтэй нээлттэй болгох, төрийн үйлчилгээ болон аймгийн талаарх мэдээллийг шуурхай хялбар авах боломжийг нэмэгдүүлэх.

2.Нутгийн үзүүлдэг төрийн үйлчилгээг цахим “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-өөс нэг дороос үзүүлэх нөхцөл боломжийг өргөжүүлэх, үйлчилгээний хурд, чанар хүртээмжийг сайжруулах.

3.өргөдөл, гомдол , мэдээлэл өгөх ил тод нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол мэдээллийг цахим хэлбэрээр гаргах , шийдвэрлэх, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх.

4.Төрийн бус байгууллагаас саанчилсан авлигын эсрэг ил тод байдлын түншлэлд нутгийн захиргааны байгууллагууд, төрийн бус байгууллагууд нэгдэх, үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллах.

5.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

6.Төрийн байгууллага албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд чирэгдэлгүй шийдвэрлэсэн эсэх талаар иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор төрийн байгууллагууд хүлээн авсан өргөдөл, гомдлын хөдөлгөөн, шийдвэрлэлтийн мэдээллийг 7 хоног тутам нийтэд мэдээлэх буюу байгууллагын цахим хуудсанд байршуулах.

Зорилт 2.Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.Улс төрийн томилгоог зогсоох, улс төр эдийн засаг, хувийн ашиг сонирхлын нөлөөллийг бууруулах, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж томилох.

2. Төрийн албан хаагчдад ёс зүй, харилцаа, сэтгэл зүйн чиглэлээр мэргэжлийн сургагч багш нартай хамтран сургалт, уулзалт зохион байгуулах.

3. Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хяналтын мөханизмыг бүрдүүлэх;

4.Төрийн албан хаагчдын дунд хууль эрх зүйн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулах.

5. Сахилга, ёс зүйн зөрчил болон өргөдөл, гомдолд дүн шинжилгээ тогтмол хийх, зөрчил дутагдал, шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч ажиллах.

6. Олон нийт төрийн бус байгууллагын идэвх санаачилга оролцоог хангах зорилгоор Авлигын гэмт хэргийн гэрч, мэдээлэгчийг хамгаалах, авлигыг илрүүлж илчилсэн иргэнийг урамшуулах хууль тогтоомжийн талаар иргэд олон нийт болон бүх шатны төрийн байгууллагын удирдлага, ажилтан албан хаагч нарт аймгийн Прокурорын газартай хамтран сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

Зорилт 3. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.Нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллага Нийтийн сонсголын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу төсвийн хяналтын сонсголыг жил бүр зохион байгуулах.

2.Татвар төлөгчдийн төсвийн зарлагын бодлогод оролцоог нэмэгдүүлэхийн тулд мэдээллийг ил тод болгох томоохон бодлого боловсруулалтад тэднийг оролцуулах, татвар төлөгчдийн саналыг зайлшгүй тусгах арга хэмжээг зохион байгуулах.

3.Тухайн жилийн орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг тусгах.

3.Иргэдийг орон нутгийнхаа төсвийн үйл ажиллагаанд идвэхитэй оролцох талаар сургалт сурталчилгаа, мэдээллийг оновчтой хэлбэрээр зохион байгуулах, түгээх.

4.Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын протокол, шийдвэрлэсэн төсөв болон түүний хэрэгжилтийн талаар иргэд олон нийтэд мэдээлж хэвших.

5.Аймгийн Төрийн аудитын байгууллагаас гаргасан акт, албан шаардлага зөвлөжмийн хэрэгжилтийг байгууллагууд шилэн данс болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх.

**Зорилт 4. Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх.  
Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах

2.Худалдан авах ажиллагаа/төндөр/-ны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх.

3. Төсвийн хөрөнгөөр баригдсан барилга байгууламж, үл хөдлөх эд хөрөнгийн төсөв, гүйцэтгэсэн байгууллага баталгаат хугацаа ашиглалтын байдлын талаар мэдээллийг цахим хэлбэрээр ил тод болгох.

4.Төндөрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи мэдээлэл, хуулийн үндэслэлийг ил тод нээлттэй мэдээлдэг болгох.

5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах.

**Тав. Хөтөлбөрийн санхүүжилт**

1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймаг, сумын Засаг дарга батлан хэрэгжилтийг хангах бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж батлуулна.

2.Хөтөлбөрийн санхүүжилт нь орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

**Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгэ үнэлгээ, түүний зохион байгуулалт, хэрэгжилтийг тайлагнах.**

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан орон тооны бус зөвлөл эрхэлнэ. Орон тооны бус зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй байна.

2. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, зөвлөлийн дэргэдэх олон нийтийн хяналтын дэд зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хагас жил 06 дугаар сарын 25-ны дотор, жилийн эцсийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 05-ний дотор орон тооны бус зөвлөлд хүргүүлнэ.

4. Орон тооны бус зөвлөл нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.

5.Хөтөлбөрийн хэрэгжилт явц үр дүнгийн талаарх мэдээ тайланг цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд, ил тод нээлттэй мэдээлнэ.

**Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:**

№	Шалгуур үзүүлэлтүүд	Өнөөгийн түвшин	Тоон үзүүлэлтүүд	Зорилтод түвшин /он/			Үр нөлөө 2019-2021
				2019	2020	2021	

1.	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ын байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын шударга байдлын үнэлгээ	59,3	-	-	80,0	-	Авлигын эсрэг хуулийн 18.1.7-д заасны дагуу "Төрийн үйлчилгээ авсан иргэд иргэд байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх" гэж заасны дагуу судалгаа гаргахад шударга байдлын үнэлгээ сайжирсан байна.
2	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонрхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалт сурталчилгаа /тоо, хувиар/	Сургалтын тоо	-	9	3	4	5	Албан хаагчдын мэдлэг, шударга байдлын түвшин дээшилж, сахилга хариуцлагын тогтолцоо сайжирна.
		Хамрагдсан төрийн албан хаагчдын хувь	-	-	50 хувь	70 хувь	90 хувь	
3.	Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэх, үйлчилгээг шуурхай, нээлттэй хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх		8	9	2	3	4	Төрийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх нөхцөл боломжийг өргөжүүлж, үйлчилгээний хурд, чанар хүртээмжийг сайжруулсан байна.
4.	Төрийн албан хаагчдын гаргасан ёс зүйн зөрчлийн тоо		25	-	15	10	5	Сахилга, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн сахилга, ёс зүйн зөрчлийг бууруулсан байна.
5.	Төрийн албан хаагчдын мэдлэг ур чадвар, ёс зүйг дээшлүүлэхэд чиглэгдсэн зорилтот арга хэмжээний тоо		1	6	3-аас доошгүй	3-аас доошгүй	3-аас доошгүй	Төрийн албан хаагчдын мэргэшил ур чадвар дээшилж, өөрийгөө хөгжүүлэх арга барилд суралцаж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломж бүрдэнэ.
6.	Нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллага Нийтийн сонголын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу төсвийн хяналтын сонголыг жил бүр зохион байгуулна.		-	6	2	2	2	Төсөв ил тод, мэдээлэл хүртээмжтэй болсон үед иргэдийн оролцоо аяндаа идэвхжиж, оролцоонд суралцана.
7.	Иргэдийг орон нутгийнхаа төсвийн үйл ажиллагаанд идвэхтэй оролцохыг ухуулах сурталчилгаа, мэдээллийг оновчтой хэлбэрээр түгээх, иргэдийг оролцоонд сургах иргэдээ сонсох аяныг өрнүүлэх.		-	6	3-аас доошгүй	3-аас доошгүй	3-аас доошгүй	Төсвийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл ойлгомжтой, үйл ажиллагаа төсөл хөтөлбөр нэг бүрээр иргэд олон нийтэд хүрч, төсвийн үйл ажиллагаанд дахь иргэдийн оролцоо сайжирсан байна.



8.	Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр тухайн онд хийх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний саналыг иргэдээр нээлттэй болон цахим хэлбэрээр хэлэлцүүлж, иргэдээс гарсан саналуудыг төсвийн төсөлд тусгах.	1150		5000	9000	10000	орон нутгийн төсвийн төсөлд иргэдээс санал авч тусгах ажил хэвшиж, мэдээлэл, тоо баримттай болсон байна.
8.	Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх.	98,2		100	100	100	Төсвийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах төсвийн зарлагын мэдээлэл, төсвийн санхүүжилттэй бараа Үйлчилгээний нийлүүлэлтийн талаарх мэдээлэл ил тод нээлттэй болсон байна.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 17

Есөнбулаг сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл бололцоог нь хангах, чадавхижуулах зорилгоор Удирдлагын академийн сургалтад хамруулахад 4000 000 /дөрвөн сая/ төгрөгийг зарцуулсугай.

2. Тэргүүлэгчдийн Удирдлагын академийн сургалтад хамруулахад зарцуулагдах 4 000 000 /дөрвөн сая/ төгрөгийг Төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлаас гаргаж зарцуулахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Амарзаяа/, ня-бо /Г.Соёлоо/ нарт зөвшөөрсүгэй.



ДАРГА  Д.БАТЖАРГАЛ